Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежментийн систем

Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө

ГАРЧИГ ДУГААР **ХУУДАСНЫ**

ТАНИЛЦУУЛГА 4
1.1 Зорилго 4
1.2 Үйлчлэх цар хүрээ 4
1.3 Хэрэгжүүлж эхлэх хугацаа 4
1.4 Эрх хэмжээ ба удирдлага 4
2 ХАМРАХ ХҮРЭЭ 5
2.1 Менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ 5
2.2 Бусад менежментийн төлөвлөгөөтэй давхцах тухайд 5
3 ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА 5
3.1 Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол үүрэг, хариуцлага 5
3.2 Голлон хариуцах талууд 6
4 ТӨСЛИЙН СТАНДАРТУУД 6
4.1 Монгол улсын холбогдох хууль тогтоомж 7
4.2 Холбогдох Монгол улсын стандартууд 7
4.3 БОНБНҮ-ний шаардлагууд 7
4.4 Холбогдох олон улсын стандарт, удирдамжууд 7
4.5 Сентеррагийн стандартууд 9
5 НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ БА МЕНЕЖМЕНТИЙН ХЯНАЛТ 9
5.1 Хураангуй 9
5.1.1 Одоогийн нөхцөл байдал 9
5.1.2 Биологийн олон янз байдлын менежментийн ерөнхий арга барил 9
5.1.3 Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөлт 11
5.1.4 Асуудлууд болон нөлөөллийн үнэлгээ 12
5.1.5 Харь зүйл 12
5.1.6 Хуучин төрхөнд нь оруулах ба нөхөн сэргээх 12
5.1.7 Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалал 12
5.1.8 Осол зөрчил ба үл нийцэл 13
5.2 Төлөвлөгөөний зорилго, зорилтууд 13
5.3 Гол оролцогч талууд 13
5.4 Менежментийн хяналт 14
6 ХЭРЭГЖИЛТИЙН ХУВААРЬ 16
6.1 Менежментийн төлөвлөгөөг хянах, засаж сайжруулах 16
7 ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ 17
7.1 Хяналт шинжилгээнд тавигдах шаардлагуудын тойм 17

7.2 Хяналт шинжилгээний гол үйл ажиллагаа 18

8 СУРГАЛТ 19

9 АУДИТ БА ТАЙЛАГНАЛ 20

9.1 Дотоод аудит 20

9.2 Гадаад аудит 20

9.3 Бүртгэл хөтлөх 20

ХҮСНЭГТҮҮД

Хүснэгт 1: Гол үүрэг, хариуцлага 5
Хүснэгт 2: Менежментийн гол хяналтууд 15
Хүснэгт 3: Хяналт шинжилгээний гол арга хэмжээнүүд 19

ТАНИЛЦУУЛГА

1.1 Зорилго

Сентерра Гоулд Инк (Сентерра) энэхүү БОЯБМТ-г охин компани нь болох Бороо Гоулд Компаниар (БГК) дамжуулан Гацууртын уурхай дахь Төслийн үйл ажиллагаа, уурхайн тээврийн маршрут болон Бороогийн уурхай дахь боловсруулах байгууламжуудтай холбогдох биологийн олон янз байдлын менежментийг гүйцэтгэхэд зориулж боловсруулав. Энэ нь Сентеррагийн зүгээс Гацууртын төслийн байгаль орчин, нийгмийн менежментийг хэрэгжүүлэхээр боловсруулсан цуврал менежментийн төлөвлөгөөнүүдийн нэг юм. Тус Менежментийн төлөвлөгөөний ерөнхий зорилго нь:

- БОЯБМТ-ний хамрах хүрээ, хэрэгжилтийг голлон хариуцагч талуудыг тогтоох;
- Төлөвлөгөөг хэрэгжүүлэх талуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлох;
- Тус төлөвлөгөөнд баримталвал зохих ‘Төслийн стандартууд’-ыг тоймлон тусгах;
- Энэ төлөвлөгөөнд хамааралтай төслийн үүрэг амлалт, үйл ажиллагааны журам болон удирдамжуудыг тодорхойлох;
- Хяналт шинжилгээ, тайлагнах журам, тэр дундаа гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлох;
- Сургалтанд тавигдах шаардлагуудыг тодорхойлох;
- Дагалдах материал, мэдээллийн лавлагааг зааж өгөхөд тус тус оршино.

1.2 Үйлчлэх цар хүрээ

Энэхүү БОЯБМТ-нд заасан шаардлагуудыг уурхай, хүдэр тээвэрлэлт, хүдэр боловсруулалт гэхчлэн Гацууртын төслийн үйл ажиллагааны бүхий л чиглэлд дагаж мөрдөх бөгөөд төслийн барилга, ашиглалт болон хаалтын үе шатуудыг хамарна. Тус төлөвлөгөөний шаардлагуудыг Гацууртын төслийн үйл ажиллагаанд оролцож буй БГК-ийн нийт ажиллагсад, гэрээт гүйцэтгэгчид биелүүлж ажиллана.

Энэ менежментийн төлөвлөгөө нь БГК-ийн боловсруулсан Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчны менежментийн системийн (ЭМААБОМС) нэг хэсэг ба Монгол улс дахь Сентерра/БГК-ийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэм, аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн менежментэд баримтлах ерөнхий бүтцийг хангах юм. БГК-ийн Байгаль орчин, нийгмийн менежментийн системийн ерөнхий бүтцэд ямар нэг нэмэлт өөрчлөлт орвол тус төлөвлөгөөнд мөн өөрчлөлт орохыг үгүйсгэхгүй.

1.3 Хэрэгжүүлж эхлэх хугацаа

Энэхүү төлөвлөгөөг Гацууртын төслийн барилгын ажил эхэлсэн өдрөөс хэрэгжүүлнэ.

1.4 Эрх хэмжээ ба удирдлага

БГК-ийн Байгаль орчны асуудал эрхэлсэн захирал энэ төлөвлөгөөг хариуцан ажиллана. Төслийн зураг төсөл, журмуудад орсон өөрчлөлтийг тусгахын тулд илүү ойрхон давтамжтайгаар шинэчлэх шаардлага үүсэхгүй бол энэхүү төлөвлөгөөнд ямар нэг өөрчлөлт, шинэчлэлт хийх шаардлагатай эсэхийг тогтоох зорилгоор хоёр жилд нэг удаа хянан нягтална.
Менежментийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах хүсэлтийг төлөвлөгөө хариуцагчид гаргах бөгөөд аливаа өөрчлөлт нь өөрчлөлтийн менежментийн журамд заагдсан хянах болон батлах зэрэг дараалаар дамжин шийдвэрлэгдэнэ.

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.
ХЭВЛЭСЭН ӨДӨР: 2016-05-11

2 ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 Менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ

БОЯБМТ нь Гацууртын төслийн бүхий л үйл ажиллагааг хамрах бөгөөд гэрээт гүйцэтгэгчдийн үйл ажиллагаа мөн үүнд хамаарна. БОЯБМТ-г Гацууртын уурхай талбай дахь олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа болон Бороогийн уурхай дахь хүдэр боловсруулах үйл ажиллагаанд дагаж мөрдөнө. БОЯБМТ нь төслийн барилга, ашиглалт, хаалтын үе шатуудад мөрдөгдөнө. Төлөвлөгөөний хамрах хүрээнд Бороогийн уурхайн талбай дахь хаягдлын менежментийн байгууламжийн үйл ажиллагаа багтах ба энд зэрлэг амьтдад учирч болох тодорхой эрсдлүүд байгаа юм. Харин хаягдлын менежменттэй холбоотой зарим арга хэмжээ тухайлбал, бохир ус цэвэрлэх, хашаа саад барих гэх мэт үр дүнтэй хамгааллын механизмууд энэ төлөвлөгөөнд багтаагүй болно. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд Гацууртын уурхайн талбай доторх замын хөдөлгөөн, Бороогийн уурхай руу хүдэр тээвэрлэх, Гацууртын уурхай, Бороогийн алтны уурхай хооронд ажилчдыг зөөх болон түлш шатахуун, төслийн хамааралтай бусад тоног төхөөрөмж, хэрэглээний зүйлсийг тээвэрлэх ажил орно.

2.2 Бусад менежментийн төлөвлөгөөтэй давхцах тухайд

Энэхүү төлөвлөгөө нь БГК-ийн ЭМААБО-ы менежментийн системд тодорхойлогдож, Гацууртын төсөлд зориулан боловсруулагдсан ерөнхий багц менежментийн төлөвлөгөөнүүдийн нэг хэсэг юм.

- Гацууртын төслийн замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө;
- Гацууртын уурхайн хаалтын төлөвлөгөө;
- БГК-ийн Хаягдлын менежментийн байгууламжийн зааварчилгаа;
- Гацууртын уурхайн Гадаргын усны менежментийн төлөвлөгөө.

3 ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

3.1 Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол үүрэг, хариуцлага

Энэхүү төлөвлөгөөг хариуцан хэрэгжүүлэх үүрэгтнүүд ба хариуцлагыг энэ хэсэгт тоймлон үзүүлэв.

Хүснэгт 1: Хариуцагч ба хариуцлага

Хариуцагч	Хариуцлага
БГК-ийн ерөнхий Захирал	Төсөл нь энэ төлөвлөгөөнд заагдсан стандартууд болон бусад шаардлагуудыг мөрдөн ажиллах байдлыг хангуулах. Энэ төлөвлөгөө болон үүний хэрэгжилтэд шаардагдах нөөц хөрөнгийг батлах.
Байгаль орчны асуудал эрхэлсэн захирал	Төлөвлөгөөний хамрах хүрээ, хэрэгжилтийг ерөнхийд нь хариуцах. Төлөвлөгөөний боловсруулалт, хяналт шинжилгээ, засвар өөрчлөлтийг хариуцах. Төлөвлөгөөнд тусгагдсан шаардлагуудыг Гацууртын төслийн дээд шатны удирдлагын багийнханд мэдээлэх. Төлөвлөгөөний үр дүнтэй хэрэгжилтийг бататган хангах үүднээс нөөц бололцоо, хариуцлагыг Байгаль орчны хэлтсийн албан хаагчдад хуваарилах. Төслийн шаардлагуудын дагуу энэхүү төлөвлөгөө болон түүнд заасан хянах давтамжыг хянан нягтлах.

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.
ХЭВЛЭСЭН ӨДӨР: 2016-05-11

Хариуцагч	Хариуцлага
Байгаль орчны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	Бусад хэлтсүүд, хэрэгжүүлэгч байгууллагууд, оролцогч талуудын үйл ажиллагааны зохицуулалтын хангаж, төлөвлөгөөг хуваарийн дагуу хэрэгжүүлэх. Энэхүү төлөвлөгөөний шаардлагуудыг хангах төрөл бүрийн журам, ажлын зааварчилгаа болон хөтөлбөр боловсруулах. Тус төлөвлөгөөний шаардлагууд зөрчигдсөнийг илтгэхүйц арга хэмжээ эсвэл осол зөрчлийг мэдээлэх, засаж залруулах. Эл төлөвлөгөөний хэрэгжилтэд шаардагдах боловсон хүчнийг удирдлага, зохион байгуулалт, хяналтаар хангах.
Гэрээт гүйцэтгэгчид	Хяналтад нь байгаа бүхий л өмч хөрөнгө БГК-ийн бодлого, журмуудад нийцэж байх явдлыг хангах. Холбогдох гэрчилгээ, тусгай зөвшөөрлийнхөө хуулбарыг хууль, журмын дагуу гаргаж өгөх. Байгаль орчны менежментийн талаарх БГК-ийн шаардлагуудыг биелүүлэх. Байгаль орчинд бодитоор учирсан болон учирч болзошгүй бүхий л нөлөөллийн талаар холбогдох ахлах ажилтан эсхүл удирдах албанд мэдээлэх.
Ажиллагсад	Менежментийн төлөвлөгөө болон холбогдох Гацууртын байгаль орчны бодлого, журмуудаад заасан үүргүүдээ биелүүлэх. Байгаль орчинд бодитоор учирсан болон учирч болзошгүй бүхий л нөлөөллийн талаар холбогдох ахлах ажилтан эсхүл удирдах албанд мэдээлэх

3.2 Голлон хариуцах талууд

Энэхүү менежментийн төлөвлөгөөний холбогдох хэсгүүдийн хэрэгжилтийг дараах хэлтэс нэгжүүд, албан тушаалтнууд голлон хариуцна:

- Үйл ажиллагаа эрхэлсэн ерөнхий менежер нь уурхайн төлөвлөлт, нөхөн сэргээлт, хаалтын төлөвлөлт түүнчлэн ЭМААБО-ы менежментийн системийг үр дүнтэй хэрэгжүүлэх нөөц бололцоог хангах талыг хариуцна;
- Уурхайн менежер – газар хөндөх үйл ажиллагааг багасгах, уурхайн замын хөдөлгөөний менежментийг хэрэгжүүлэх, уурхайн нөхөн сэргээлт, хаалтын болон гадаргын усны менежментийн хэрэгжилтийг хариуцна;
- БГК-ийн Ложистик буюу материал, техникийн хангамж, тээвэрлэлт хариуцсан менежер – тээвэрлэлт хариуцсан гэрээт гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулах, удирдан зохион байгуулах, тээврийн үйлчилгээг хэрэгжүүлэх талыг хариуцна;
- БГК-ийн бутлалт, нунтаглалтын ажиллагаа хариуцсан менежер – зэрлэг амьтдыг хаягдлын байгууламжууд болон аюултай материалаас хамгаалахыг батлах талыг хариуцна.

4 ТӨСЛИЙН СТАНДАРТУУД

Холбогдох стандартуудыг төслийн бүхий л үйл ажиллагаанд заавал дагаж мөрдөнө (“Төслийн стандартууд”).

4.1 Монгол улсын холбогдох хууль тогтоомж

БОЯБМТ-нд баримталвал зохих холбогдох Монгол улсын хууль тогтоомжууд:

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995);
- Байгалийн ургамлын тухай хууль (1995);
- Газрын тухай хууль (2012);
- Ойн тухай хууль (2012);
- Усны тухай хууль (2012);
- Амьтны тухай хууль (2012);
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль (2012);
- Газрын хэвлийн тухай хууль (1988);
- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012);
- Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн тухай хууль (1995);
- Ой хээрийг түймрээс хамгаалах тухай хууль (1996).

4.2 Холбогдох Монгол улсын стандартууд

БОЯБМТ-нд баримталвал зохих Монгол улсын стандартууд (MNS):

- Байгаль орчны хамгаалал. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтэд тавигдах ерөнхий шаардлага (MNS 17.5.1.19-92);
- Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. MNS 5914:2008;
- Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал. MNS 5915:2008;
- Байгаль орчин. Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт. MNS 5916:2008;
- Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрыг нөхөн сэргээх. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5917:2008;
- Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5918:2008;
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам (2014);
- Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх журам (2003).

4.3 БОНБНҮ-ний шаардлагууд

Энэхүү төсөлд зориулан хийсэн Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнүүдэд (БОНБНҮ) байгаль орчны менежмент, хяналт шинжилгээний шаардлагуудыг тоймлон тусгасан. Дараах БОНБНҮ-нүүдэд тусгагдсан үүрэг амлалтууд тус төлөвлөгөөнд хамаарна. Үүнд:

- БИОИСЭЛДҮҮЛЭЛТИЙН® үйлдвэрийн БОНБНҮ (Натур Фрейндли ХХК, 2010);
- Гацуурттын тээврийн замын БОНБНҮ (Газар Эко, 2006);
- Бороогийн алтны уурхайн БОНБНҮ-ний нэмэлт тодотгол (Натур Капитал, 2015).

4.4 Холбогдох олон улсын стандарт, удирдамжууд

Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас (ЕСБХБ) Гацууртын төсөлд хамааралтай олон улсын стандартуудыг тодорхойлсон. Тухайлбал:

- ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлагууд (2014) (ялангуяа Гүйцэтгэлийн шаардлага 1: Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, асуудлуудын үнэлгээ ба менежмент; Гүйцэтгэлийн шаардлага 3: Нөөцийн үр ашигтай хэрэглээ, бохирдлоос сэргийлэх ба бууруулах; Гүйцэтгэлийн шаардлага 6: Биологийн олон янз байдлыг хамгаалах, амьд байгалийн нөөцийн тогтвортой байдлын менежмент.

Үүнээс гадна Олон Улсын Санхүүгийн Корпорациас 2012 онд боловсруусан байгаль орчин, нийгмийн стандартуудыг уг төсөлд баримтлана:

  - Гүйцэтгэлийн стандарт 1 – Байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ ба менежмент;
  - Гүйцэтгэлийн стандарт 3 – Нөөцийн үр ашигтай хэрэглээ ба бохирдлоос сэргийлэх;
  - Гүйцэтгэлийн стандарт 6 – Биологийн олон янз байдлыг хамгаалах, амьд байгалийн нөөцийн тогтвортой байдлын менежмент;
  - Удирдамж 1.3 – Бохир ус болон орчны усны чанар;
  - Удирдамж 1.4 – Ус хадгалалт, хамгаалалт;
  - Удирдамж 1.6 – Хог хаягдлын менежмент;
  - Удирдамж 1.7 – Дуу чимээ;
  - Удирдамж 1.8 – Бохирдсон газар хөрс.

- Төсөлд баримтлах олон улсын бусад стандартуудад Цианидын Менежментийн Олон Улсын Институтийн (ЦМОУИ) Алтны уурхайн үйл ажиллагааны арга туршлагын код орно. Ялангуяа Сентерра хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах үүднээс цианидын технологийн уусмал болон хаягдал шингэний менежментэд баримтлах стандартуудыг багтаасан Арга туршлагын кодод нэгдэж баталсан.
- Энэ заавар зөвлөмжий дагуу Сентеррад тавигдах шаардлагууд:
  - Болзошгүй тохиолдолд баримтлах төлөвлөгөө, хяналт шалгалт болон урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээний журмуудаас бүрдсэн хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн менежмент, үйл ажиллагааны системийг хэрэгжүүлэх;
  - Цианидын хэрэглээг багасгах менежмент, үйл ажиллагааны системийг нэвтрүүлэх, тэгснээр бутлуурын хаягдал дахь цианидын концентрацыг хязгаарлах;
  - Бодис алдагдахаас сэргийлэхэд чиглэсэн усны менежментийн цогц хөтөлбөр хэрэгжүүлэх;
  - Шувууд, бусад зэрлэг амьтад, мал сүрэгт цианидын технологийн уусмалаас үзүүлэх сөрөг нөлөөллөөс хамгаалах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх;
  - Гадаргын усанд шууд ба шууд бусаар цианидын технологийн уусмал алдагдаснаас учрах нөлөөллөөс загас болон зэрлэг амьтдыг хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
  - Газрын доорх усны үр ашигтай хэрэглээг хамгаалах үүднээс цианид агуулсан байгууламжаас нэвчилт явагдахаас сэргийлэх менежментийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
  - Технологийн процессын нөөцлүүр болон шугам хоолойнуудаас бодис асгарах, халихаас урьдчилан сэргийлэх, тараахгүй барьж тогтоох арга хэмжээгээр хангах;
  - Цианидын байгууламжууд нь хүлээн зөвшөөрөгдсөн инженерчлэлийн стандарт, техникийн шаардлага, үзүүлэлтүүдийн дагуу баригдаж гүйцэтгэгдсэн байх явдлыг баталгаажуулах үүднээс чанарын хяналт, чанарын баталгааны журмуудыг хэрэгжүүлэх;
  - Цианидын хэрэглээнээс зэрлэг амьтан, гадаргын болон газрын доорх усны чанарт үзүүлэх нөлөөллийг үнэлэх хяналт шинжилгээний хөтөлбөрүүд хэрэгжүүлэх.

4.5 Сентеррагийн стандартууд

Ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчныг хамгаалах, тогтвортой хөгжлийн бодлогуудыг агуулсан Сентеррагийн корпорацийн бодлогуудын хүрээнд энэхүү төлөвлөгөөг боловсруулав.

5 НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ БА МЕНЕЖМЕНТИЙН ХЯНАЛТ

5.1 Хураангуй

Энэ баримт бичигт Гацууртын төслөөс шууд ба шууд бус замаар үүсч болзошгүй биологийн олон янз байдалд учрах эрсдэлийг бууруулах Сентеррагийн хүлээсэн үүрэг амлалт, арга барилыг тоймлон тусгав.

5.1.1 Одоогийн нөхцөл байдал

<u>Ургамлын аймаг</u>

Гацууртын судалгааны талбай нь Монгол-Дагуур болон Хэнтийн ургамал, газар зүйн мужлалын хил хязгаарт оршдог учраас ойт хээрийн ургамлын бүлгэмдлийн төрөл дотроо зүйлийн олон янз байдал өндөр байдаг. Газрын гадарга нь нам өвслөг ургамал зонхилсон нуга болон чийгсэг, холимог ойн бүлгэмдлийн төрлийг илтгэх нам дор газар, бэл толгодоос олон янзын холимог ой болон хуш, нарс зонхилсон бүлгэмдлийн төрлийг илтгэх эгц цавчим, хуурай уулын энгэр бэлээс тогтдог. Бургас-хус бүхий голын эрэг орчмын бүлгэмдлийн төрөл нь шороон ордын олборлолтоор эвдэрсэн газрын дээд талаар Гацууртын гол дагуу оршино. Шороон ордын олборлолт явагдсан газрууд дээр болон орон нутгийн замууд дагуух эвдэрсэн хөрсөн дээр анхдагч сукцессын ургамлын зүйлүүдээс бүрдэх хөл газрын ургамлын бүлгэмдэл зонхилон ургана.

<u>Амьтны аймаг</u>

Гацууртын судалгааны талбайд байршин нутагшдаг зэрлэг амьтад нь бор гөрөөс (*Capreolus pygargus*) зэрэг цөөн тооны том хөхтөн, жижиг болон дунд хэмжээний биетэй хөхтөн амьтад, олон зүйлийн суурин болон нүүдлийн шувуудаас бүрддэг. Зүйлийн бүрдэл нь улирлын шинжтэйгээр харилцан адилгүй байх бөгөөд өмнө нь хийгдсэн хээрийн судалгааны үед бүртгэгдсэн зүйлүүдээс өөр зүйлүүд тус нутаг дэвсгэрт нэмж тохиолдох магадлалтай. Хавар, зуны улиралд зүйлийн олон янз байдал хамгийн баялаг байх ба энэ үед тус нутагт үржиж, өндөглөн зусдаг шувууд нүүдэллэн ирдэг. Төслийн байршил нь ямар нэг тусгай хамгаалалттай газрын хил хязгаартай давхцахгүй ба Монгол улсын улаан ном, Дэлхийн байгаль хамгаалах холбооны (IUCN) улаан дансны ховор болон эрсдэлтэй ангилалд багтсан ямар нэг амьтны зүйл байхгүй.

5.1.2 Биологийн олон янз байдлын менежментийн ерөнхий арга барил

Энэ менежментийн төлөвлөгөөний зорилго нь Гацууртын төсөл дэх биологийн олон янз байдлын менежментийг тодорхойлогдсон биологийн олон янз байдлын үнэ цэнд учирч болзошгүй хомсдол, доройтлоос зайлсхийх тэргүүн туршлагын арга аргачлалын дагуу гүйцэтгэхийг батлах, мөн уурхайн ашиглалт дуусахад тогтвортой уурхайн нөхөн сэргээлт, хаалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оршино.

Энэ зорилгод дараах Биологийн олон янз байдлын менежментийн гол удирдамжуудыг мөрдлөг болгох замаар хүрсэн байна. Үүнд:

- Боломжтой бол чухал амьдрах орчныг шууд хөндөхөөс зайлсхийх;
- Ургамлан бүрхэвчийг сүйтгэх, хөрс хөндөх ажиллагааг боломжит хамгийн бага түвшинд хүртэл нь багасгах;
- Төсөлд хамааралтай тээврийн хэрэгсэлд зэрлэг амьтан мөргүүлэх, дайруулах нөлөөг багасгах;

- Хаягдлын менежментийн байгууламж дахь усны чанар зөвшөөрөгдсөн хэмжээний нөхцлүүдэд нийцэж байх, шувууд болон бусад зэрлэг амьтдад хор хөнөөлгүй байх явдлыг бататгах үүднээс баяжуулах үйлдвэрийн хаягдлыг цэвэрлэх;
- Ил уурхай, ус цэвэрлэх цөөрөм, аюултай материал хадгалах талбайд зэрлэг амьтан нэвтрэхээс сэргийлэх;
- Зэрлэг амьтдын цугларалтыг багасгахад чиглэсэн ахуйн хог хаягдлын менежмент хэрэгжүүлэх;
- Уурхайн ажиллагсад, гэрээт гүйцэтгэгчдийг уурхайн харъяалалын ажлын талбар, барилга байгууламжуудад байрлах болон ажил үүргээ гүйцэтгэх үедээ зэрлэг амьтан агнах, ургамал болон түлшний мод түүхийг хориглох;
- Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх.

Гацуурт дахь биологийн олон янз байдлын менежментийн өдөр тутмын үйл ажиллагааны илүү нарийвчилсан чиглэлүүдийг тусгасан доорх төлөвлөгөө, журмуудыг энэхүү Менежментийн төлөвлөгөөнд хавсарга болгон хэрэгжүүлнэ. Эдгээр журмуудаас гадна тухайн үеийн нөхцөл байдал, шаардлагаас хамааараад Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөөний хавсралт болохнэмэлт журам боловсруулагдаж болно.

- Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөөнд төсөлд хамааралтай тээврийн хэрэгслүүдийн баримтлах хурдны хязгаар, зэрлэг амьтан зам хөндлөн гарах газруудад тэмдэг, тэмдэглэгээ байршуулах зэрэг арга хэмжээ тусгагдана;

- Усны менежментийн төлөвлөгөөнд Гацуурт дахь гадаргын болон газрын доорх усны менежмент тусгагдсан ба үүнийг хэрэгжүүлснээр зэрлэг амьтад Гацууртын уурхайгаас доошихурсгал дагуух усан хангамжаас чөлөөтэй ундаалж, усан орчны экосистем хамгаалагдсан байх юм. Түүнчлэн уурхайн байгууламжуудын эргэн тойрон дахь гадаргын усны голдрилд хэсэгчилсэн тохируулга хийх, тэгснээр тохируулга хийгдсэн гадаргын ус уурхайн үйл ажиллагааны нөлөөнд өртөхөөс сэргийлэх, урсгал дагуух усны чанарыг зөвшөөрөгдсөн стандарт хэмжээнд байлгахын тулд уурхайн нөлөөнд өртсөн бүхий л усыг хуримтлуулах, цэвэрлэх, зайлуулах гэх мэт арга хэмжээнүүд орсон.

- БГК-ийн хаягдлын менежментийн байгууламжийн зааварчилгаанд Бороогийн уурхайн байгууламж дахь зэрлэг амьтдыг хамгаалах арга хэмжээнүүд багтах ба түүн дотроо шувууд болон бусад зэрлэг амьтдыг хамгаалахын тулд цианид, хүнцлийн агууламж хэмжээ хууль, стандартад заасан хязгаар болон зөвшөөрөгдсөн дээд хэмжээн дотор байгааг батлах арга хэмжээ, мөн хаягдлын менежментийн байгууламж руу амьтад нэвтрэн орох магадлалыг багасгах зорилготой хашаа татах зэрэг арга хэмжээнүүд орно.

- Гацууртын уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө нь Гацууртын уурхайн БОНБҮ-ний тайлан болон төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн судалгаанд орсон болно. Тус төлөвлөгөөнд Гацуурт дахь олборлолт дуусч, Бороо дахь хүдэр боловсруулалт дууссаны дараах уурхайн нөхөн сэргээлт, менежментийн тусгайлсан зорилтуудыг тусгасан. Биологийн олон янз байдлын менежментэд хамааралтай дараах зорилтууд байна:

    - Хүчиллэг чулуулгийн урсац эсвэл уурхайтай холбоотой газрын доорх усны нөлөө зэрэг байгаль орчны сөрөг нөлөөг бууруулах, арилгах;
    - Уурхайн талбайг уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө байсан үеийнхтэй нь ойролцоо газар ашиглалтын төлөвт буцаан оруулах. Газар ашиглалтын төрлүүд нь малын хадлан бэлчээр, зэрлэг амьтдын амьдрах орчин зэрэг болно;
    - Уурхайн талбайгаас гаднах нөлөөллийг багасгах арга хэмжээний хүрээнд одоогийн байгаа суваг, шуудууны нэвчилт, элэгдэл эвдрэл, хурдас чулуулаг, доройтол үүсэх явдалд хяналт тавих;
    - Байнга засварлах шаардлагагүй батлагдсан арга, аргачлалуудын дагуу нөхөн сэргээлтийн туршлагыг ашиглах.

Эдгээр зорилтуудыг харгалзан нөхөн сэргээлтийн үйл ажиллагаагаар дараах зүйлсийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хөндөгдсөн газруудыг аюулгүй төлөв байдалд хүргэж тогтворжуулах;
- Хөндөгдсөн ба хөндөгдөөгүй газруудыг аль алиныг нь шаардлагагүй, зохисгүй доройтлоос хамгаалах.

Гацууртын уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг гүйцэтгэхдээ Сентерра нь Гацууртын голын хөндийд урьд нь явагдаж байсан шороон ордын олборлолтын үйл ажиллагаагаар эвдэрсэн талбайн ихэнх хэсгийг нөхөн сэргээнэ.

Гацуурт болон Бороогийн уурхай дээр нөхөн сэргээлтийг хийхдээ ил уурхай, цөөрөм рүү зэрлэг амьтан нэвтрэн орох боломжыг багасгах саад хаалт барих; хаягдлын менежментийн байгууламжийг нөхөн сэргээх; бохирдуулагчын эх үүсвэрүүдийг цэвэрлэх эсхүл нөхөн сэргээх, зэрлэг амьтны амьдрах орчныг боломжтой тохиолдолд нөхөн сэргээх зэрэг ажлыг багтаан гүйцэтгэнэ.

5.1.3 Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөлт

Нөлөөллийн үнэлгээний судалгаанд тодорхойлсончлон төслийн бүтээн байгуулалтын үр дүнд биологийн олон янз байдалд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөллүүд:

- Ил уурхай, хаягдлын овоолго, уурхайн зам болон туслах байгууламжуудад шаардагдах ургамлан нөмрөгийг (үүнд мөн ой модтой газар орно) хуулсны улмаас үүсэх амьдрах орчны шууд хомсдол;
- Олборлолт, ашиглалтын үед болон хаалтын дараа хүчиллэг чулууллагийн урсацын нөлөөлөлд өртсөн хөрсний улмаас үүсэх амьдрах орчны шууд бус хомсдол;
- Гацууртын үйл ажиллагааны үр дүнд тухайн газар нутагт хүм амын тоо нэмэгдэх, Гацууртад нэвтрэх боломж өссөнөөр зэрлэг амьтан агнах, ургамал, мод түүх зөрчил ихсэх;
- Төслийн тээврийн замд зэрлэг амьтад тээврийн хэрэгсэлд мөргүүлж, дайруулж үхэж хорогдох;
- Уурхай болон Бороогийн ХМБ дахь бохирдолтой байж болзошгүй уснаас зэрлэг амьтад ундаалах зэргээр нөлөөлөлд өртөх.

Хэдийгээр дунд болон өндөр чанартай амьдрах орчны зарим хэсэг уурхайн талбайд хөндөгдөх боловч уурхайн байгууламжууд бий болохоор төлөвлөгдөж буй байршил болох Гацууртын хөндийн нилээд их хэмжээний газар талбай өмнө нь явагдаж байсан олборлолтын үйл ажиллагааны нөлөөгөөр хэдийнээ хөндөгдөж эвдэрсэн байсан. Одоогоор бичил уурхайн нөлөөгөөр үүссэн нүхнүүд ил задгай хэвээр, ургамалжуулаагүй байдалтай байна. Гацууртын уурхайн ойр орчмын томоохон хэмжээний газар нутгийг хамран ургах ижил төстэй ургамалжилтын нөөц болон ашиглалт дуусаны дараа хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хаалтын болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг харгалзан үзэхэд төслийн зүгээс хуурай газрын биологийн нөөц баялагт үзүүлэх нөлөөллийн хэмжээ цаашдаа буурах болно. Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр урьд өмнө нь хөндөгдсөн, нөхөн сэргээлт хийгдээгүй газрыг нөхөн сэргээх боломж бүрдэхийн зэрэгцээ төсөл хэрэгжих нутаг дэвсгэр дэх биологийн олон янз байдалд эерэгээр нөлөөлөх завшаан бий болно.

Зэрлэг амьтад тээврийн хэрэгсэлд дайруулан үхэж хорогдох магадлалыг бууруулахын тулд тээврийн замуудын хурдны хязгаарыг тогтооно. Жолооч нарыг мэдлэг олгох хөтөлбөр, сургалтанд хамруулж байгаль орчны шаардлагуудын талаар мэдлэг, ойлголттой болгоно.

ХМБ-аас хаягдал зайлуулах менежмент нь уурхайн цэвэрлэсэн хаягдалд агуулагдах хүнцэл, цианидын концентрацыг хууль, журамд заасан зөвшөөрөгдөх хязгаараас бага байлгаж шувуудад үзүүлэх нөлөөллийг багасгах зорилтыг хангана. БГК нь Сентеррагаар дамжин цианидын менежментийн олон улсын тэргүүн туршлагад тооцогддог Олон улсын цианидын менежментийн кодод *(Код)* гарын үсэг зурж нэгдсэн билээ. Энэ кодод зэрлэг амьтдад үзүүлэх нөлөөллийг багасгахын тулд ХМБ-ын усны уусмалд агуулагдах цианидын зөвшөөрөгдөх түвшний хязгаарыг зааж өгсөн байдаг. Үүнээс гадна Монгол улсын Засгийн газар ХМБ-ын усны чанарын хэмжээ хязгаарыг тогтоосон ба энэ нь дээрх кодод заасан

хязгаартай харьцуулахад илүү чанд хатуу байгаа юм. Үүний үр дүнд ХМБ-ийн уснаас шувуудад сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлал бараг байхгүй гэж үзэж байна.

5.1.4 Асуудлууд болон нөлөөллийн үнэлгээ

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр дэх суурь төлөв байдлыг нөлөөллийн үнэлгээний үйл явцад хангалттай тодорхойлсон. Энэ хүрээнд амьдрах орчны хомсдол, доройтол, гидрологийн өөрчлөлт болон бохирдлыг харгалзан үзсэн. БОНБҮ-ний үйл явцад "Үр дүнтэй хяналтын арга хэмжээ, ялангуяа Гацууртад ус цэвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлснээр биологийн олон янз байдалд ноцтой нөлөөлөл учруулахгүй" гэж дүгнэсэн. Гацууртын төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт чухал амьдрах орчны шалгуурыг хангах зүйл *(ЕСБХБ-ы ГШ-6-д тодорхойлсончлон)* тодорхойлогдоогүй болно.

5.1.5 Харь зүйл

Харь зүйлийг нутагшуулахыг төслийн эрсдэл гэж үзээгүй болно. БГК-ийн зүгээс хөл газрын ургамалд тохирсон хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнахыг дэмжихийн зэрэгцээ шаардлагын дагуу хөл газрын ургамлын хяналтын механизмыг хэрэгжүүлнэ.

5.1.6 Хуучин төрхөнд нь оруулах ба нөхөн сэргээх

Ашиглалт дуусаны дараа үлдэх хөндөгдсөн газрыг нөхөн сэргээхийн гол зорилго нь уурхайн үйл ажиллагаа явагдаж дуусанаас хойш явагдах газар ашиглалтыг дэмжих эцсийн тогтвортой газрын төрхийг бий болгоход оршино. Гацууртын уурхайн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон хуулийн шаардлагын дагуух Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд зориулан Уурхайн хаалт ба нөхөн сэргээлтийн урьдчилсан төлөвлөгөөг боловсруулсан билээ. Гацуурт дахь ашиглалтын үе шат дуусахаас гурван жилийн өмнө Уурхайн хаалт ба нөхөн сэргээлтийн нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж дуусгах ба энэ төлөвлөгөө нь газрын төрхийн тогтвортой байдал, бохирдлоос сэргийлэх болон гадаргын усны чанарыг хадгалах замаар хөндөгдсөн газруудыг нөхөн сэргээх, биологийн олон янз байдлыг үргэлжлүүлэн хамгаалахад чиглэсэн заавар, зөвлөмж бүхий арга барилыг тогтоож өгнө.

Хаалтын үед хэрэгжүүлэх нөхөн сэргээлтийн гол хөтөлбөрүүдийн нэг хэсэг нь Гацууртын голын голдрил болон голын эрэг орчмын газруудыг нөхөн сэргээх ажил байх болно. Шороон ордын олборлолтод урьд нь өртсөн Гацууртын хөндийд одоогоор янз бүрийн хэмжээтэй хад чулуу, хайрга хөглөрсөн байдалтай байна. Гацууртын голын анхны голдрил бичил уурхайнуудын нөлөөгөөр ихээхэн өөрчлөгджээ.

Гацууртын хөндийн геоморфологийн хэлбэр төрхийг Гацууртын голыг тухайн хөндийн геоморфологийн шинж чанартай тохирхуйц байршил, өргөн, гүнтэйгээр нөхөн сэргээхэд ашиглах ба ингэснээр хөндийн голдрил нь анхны төрх байдалдаа дөхөж очих юм. Хөндийн энэ эцсийн голдрилд усан орчны ургамал, макро сээр нуруугүй организмуудыг шат дараалан бий болгосноор усан орчны нөхөн сэргээлтийг хийх юм. Усан орчны бүрдлийг ийнхүү хослуулах нь олон зүйлийн загас зэрэг их хэмжээний усан орчны зүйлүүдийг дэмжих юм.

Нөхөн сэргээлт хийсэн голын эргээр бургас, ширэг улалж, зэгс гэх мэт голын эрэг дагуу ургадаг ургамлын зүйлүүдийг тариж ургуулна. Ингэснээр Гацууртын голын нөхөн сэргээлтийн хөтөлбөрийн үр дүнд голын хөндийд тохирсон, шороон ордын олборлолтын төслүүдийн нөлөөлөлд анх өртөхөөс өмнө байсан ижил төстэй биологийн олон янз байдлын үнэт зүйлсээр хангагдсан усан орчин, голын эрэг орчмын амьдрах орчны системийг бүрдүүлнэ.

5.1.7 Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалал

Гацууртын төсөлд зориулан гүйцэтгэсэн нөлөөллийн үнэлгээгээр дүйцүүлэн хамгаалаллын арга хэмжээ шаардагдах ямар нэгэн томоохон үлдэгдэл нөлөө тогтоогдоогүй. Гэсэн хэдий ч, газар хөндөх үйл ажиллагааны улмаас хомсдох ой бүхий талбайг Монголын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачлалд заасны дагуу гол оролцогч талуудтай хэлэлцүүлэг хийж боловсруулан гаргах хөтөлбөрийн дагуу дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хийхээр төлөвлөсөн. Дүйцүүлэн хамгааллын хөтөлбөрийг Монгол улсын Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаагаар батлуулах

шаардлагатай бөгөөд орон нутгийн оролцогч талуудын оролцоог хангасан байх ёстой. Ой бүхий талбайг дүйцүүлэн хамгаалахад Гацуурт дахь одоо байгаа ой мод бүхий талбайн менежментийг сайжруулах, хамгаалах хувилбарууд, уул уурхайн бус үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн Гацууртын ой мод бүхий газруудыг нөхөн сэргээх болон Гацуурт дахь орон нутгийн иргэдэд түшиглэсэн ойн менежментийг сайжруулахад чиглэсэн хөтөлбөрүүдийг дэмжих зэрэг арга хэмжээ орох боломжтой.

5.1.8 Осол зөрчил ба үл нийцэл

Ургамлын болон амьтны аймагтай холбоотой бүх осол зөрчил, үл нийцлийг баримтжуулж, бүртгэсэн байна. Тайланд хамгийн багадаа дараах мэдээллийг дэлгэрэнгүй тусгана. Үүнд:

- Тухайн тохиолдол болсон огноо, цаг хугацаа, шинж чанар;
- Тухайн тохиолдлын байж болох шалтгааныг тодорхойлох;
- Шуурхай авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлбар;
- Шаарлагатай үед авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний тайлбар.

Тухайн тохиолдлын мөрөөр хийсэн шалгалтын үр дүнг бүртгэж, биелэлтийг хангана.

5.2 Төлөвлөгөөний зорилго, зорилтууд

Биологийн олон янз байдлын талаар баримтлах Гацууртын арга барилын нийтлэг зорилтууд:

- Уул уурхайн бүтээн байгуулалт, тээвэрлэлт, хүдэр боловсруулах үйл ажиллагааны улмаас ургамлан нөмрөг, хөрсийг хөндөхөөс боломжтой бол зайлсхийх, эсвэл багасгах;
- Уурхайн тээвэрлэлтийн үйл ажиллагаа, гадаргын усыг зайлуулах, хаягдал хаях ажиллагаанд биологийн олон янз байдлын үр дүнтэй хяналтын стратегийг хэрэгжүүлэх замаар биологийн олон янз байдал, экологийн үйл явцыг боломжит, бодит түвшинд хадгалж үлдэх;
- Ашиглалт дууссаны дараа уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн үр дүнтэй стратеги хэрэгжүүлэх замаар уурхайн бүтээн байгуулалтаас биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулах;
- Төслийн бүхий л үйл ажиллагааг биологийн олон янз байдлын талаархи Монгол улсын хууль тогтоомж болон ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 6-д нийцүүлэн гүйцэтгэх явдлыг бататгах.

Энэхүү Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх замаар эдгээр зорилтуудыг биелүүлэх ба, 7.2 дахь хэсэгт нарийвчлан тусгасан гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдээр хэмжиж, үнэлгээ хийнэ.

5.3 Гол оролцогч талууд

Тус менежментийн төлөвлөгөөнд хамаарал бүхий гол оролцогч талууд:

Оролцогч тал	Хамрах/харилцан ажиллах сэдэв
Монгол улсын Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам	Ой бүхий талбайг чөлөөлөх зөвшөөрөл; Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөлт; нэн ховор, ховор амьтад болон чухал амьдрах орчны хамгаалал; байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлах.
Аймаг, сумдын захиргаа	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт болон БОНБНҮ-нд тусгагдсан үүрэг амлалтын биелэлтэд хяналт тавих.

5.4 Менежментийн хяналт

Дээр дурьдсан тодорхойлогдсон нөлөөлөл болон боломжуудад үндэслэн Гацууртын барилга болон ашиглалтын үе шатуудад дараах хяналтын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Эдгээр арга хэмжээг Байгаль орчны хэлтэсийн хариуцах ажиллах Гацууртын Биологийн олон янз байдлын хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлнэ.

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.
ХЭВЛЭСЭН ӨДӨР: 2016-05-11

Хүснэгт 2: Менежментийн гол хяналтууд

Лавлах дугаар	Хамрах сэдэв/ асуудал	Хэрэглээ/ Үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тайлбар	Хариуцах талууд	Гүйцэтгэлийн шалгуур
БОЯБ01	Хог хаягдлын менежмент	Олборлолт; Боловсруулалт; Ажилчдын байр; Тээвэрлэлт	Амьтад цугларах, харилцан үйлчлэлд орохоос сэргийлэх шингэн хаягдлын зохистой менежмент Амьтдыг хооллох, тэжээхээс сэргийлэх. Бүхий л химийн хаягдлыг зохих журмын дагуу зөв зайлуулж устгах.	Байгаль орчны хэлтэс Үйл ажиллагааны хэлтсүүд Үндсэн гэрээт гүйцэтгэгчид	Дотоод аудит, үзлэг шалгалтын хөтөлбөр
БОЯБ02	Амьтад нэтрэхийг хориглох	Олборлолт болон боловсруулалт	Ус хуримтлуулсан цөөрөмд мал, амьтан нэвтрэхээс сэргийлж хашаалах. Орон нутгийн малчдад малын эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлийн талаар мэдлэг, мэдээлэл өгөх.	Байгаль орчны хэлтэс Үйл ажиллагааны хэлтсүүд	Дотоод аудит, үзлэг шалгалтын хөтөлбөр
БОЯБ03	Амьтны аймгийг хамгаалах	Боловсруулалт	Хаягдлын байгууламж дахь цианид, хүнцлийн концентрацыг ЦМОУИ-ийн Цианидын кодод нийцсэн, хууль, журамд заасан хязгаараас доор түвшинд байлгах.	Боловсруулалтын хэлтэс Байгаль орчны хэлтэс Үйл ажиллагааны хэлтсүүд	Хаягдлын байгууламж дахь усны чанарын хяналт шинжилгээ
БОЯБ04	Ургамлан нөмрөгийг хуулах	Олборлолт	Ургамлан нөмрөгийг хуулах газруудын хил заагийг зурагжуулан тодорхойлж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг уурхайн талбайгаас гадна хязгаарлах. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрээс гадагш ажилчдын хөдөлгөөнийг хязгаарлах.	Олборлолтын хэлтэс Байгаль орчны хэлтэс Үндсэн гэрээт гүйцэтгэгчид	Дотоод аудит, үзлэг шалгалтын хөтөлбөр
БОЯБ05	Ургамлан нөмрөгийг хуулах	Олборлолт Тээвэрлэлт	Бүхий л газар хөндөх, хөрс хуулах үйл ажиллагаанд зохих ёсоор үнэлгээ хийсэн байхыг батлахын тулд газар хөндөх зөвшөөрлийн системийг санаачлан хэрэгжүүлжэх.	Байгаль орчны хэлтэс	Газар хөндөх зөвшөөрөл болон үнэлгээний бүртгэл

Лавлах дугаар	Хамрах сэдэв/ асуудал	Хэрэглээ/ Үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тайлбар	Хариуцах талууд	Гүйцэтгэлийн шалгуур
БОЯБ06	Амьтан агнах, ургамал, мод түүх	Бүгд	БГК-ийн нийт ажиллагсад, гэрээт гүйцэтгэгчдийг Бороогийн үйл ажиллагаа явагдах аливаа газар ажиллаж, амрах үедээ ан хийх, хууль бусаар ургамал, түлшний мод түүх зэрэг үйлдэл хийхийг хориглох.	Байгаль орчны хэлтэс	Осол зөрчлийн тайлан
БОЯБ07	Тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөх осол зөрчил	Тээвэрлэлт	Бүх замуудад хурдны хязгаар тогтоож, мөрдүүлэх. Харуй бүрий гэх мэт амьтдын хамгийн идэвхтэй үеүдэд тээврийн хэрэгсэл жолоодох үйл ажиллагааг хязгаарлах. Амьтад байршдаг, дамжин өнгөрдөг нь тогтоогдсон газруудад замын тэмдэг байрлуулах, хурдны хязгаарыг мөрдүүлэх. Амьтад өндөр идэвхтэй болдог, тээврийн хэрэгсэлд мөргүүлэх талаар ажилчдад мэдээлэх хүргэх.	Байгаль орчны хэлтэс Уурхайн тээврийн гэрээт гүйцэтгэгч Олборлолтын хэлтэс	Тээврийн хэрэгслийн хурдыг шалгах Тээврийн хэрэгсэлд амьтан дайрагдсан осол зөрчил.
БОЯБ09	Ой модтой талбай хомсдох	Олборлолт	БОНБҮ-ний аргачлалын дагуу Монгол улын Засгийн газар болон орон нутгийн захиргаатай хэлэлцэж, зөвлөлдсөний үндсэн дээр ой модтой талбайг дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийг боловсруулах. Уг хөтөлбөрийг үйл ажиллагаа эхлэхээс өмнө Засгийн газраар батлуулсан байхаар боловсруулах	Байгаль орчны хэлтэс Гадаад харилцаа	Дүйцүүлэн хамгааллын хөтөлбөр батлагдсан байх.

6 ХЭРЭГЖИЛТИЙН ХУВААРЬ

6.1 Менежментийн төлөвлөгөөг хянах, засаж сайжруулах

Менежментийн төлөвлөгөөг жил бүр хянах ба Гацууртын нөхцөл байдлын өөрчлөлт, үйл ажиллагааны хэрэгцээг тусгах шаардлагатай засвар, шинэчлэлийг хийнэ. Энэхүү төлөвлөгөөг хянан шинэчлэх нь төлөвлөгөөг хариуцан эзэмшдэг БГК-ийн Байгаль орчны асуудал эрхэлсэн захирлын үүрэг хариуцлага мөн.

Үйл ажиллагааны журмуудад мэдээ баримтны өөрчлөлт оруулах шаардлага үүсвэл *(Гацууртын Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин (ЭМААБО) болон орон нутгийн харилцааны менежментийн системд орсон Өөрчлөлтийн менежментийн журмуудын дагуу тодорхойлсончлон)* энэ менежментийн төлөвлөгөөг шаардлагатай тохиолдолд шинэчилж болно. Менежментийн төлөвлөгөөг хянаж шинэчлэх бүрдээ Гацууртын нийт ажилчин, албан хаагчдад энэ төлөвлөгөөний хамгийн сүүлийн хувилбартай танилцах боломжоор хангах үүднээс тухайн шинэчлэгдсэн хувилбарыг Гацууртын баримт бичгийн менежментийн системд байршуулна.

7 ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

7.1 Хяналт шинжилгээнд тавигдах шаардлагуудын тойм

Биологийн олон янз байдлын менежментийн хяналт шинжилгээний голлох үүрэг даалгаварт энэхүү төлөвлөгөөнд тусгасан нөлөөллийн хяналтын арга хэмжээнүүдийн үр дүнгийн хяналт шинжилгээ багтана. Уг хяналт шинжилгээ нь ашиглалтын үед хэрэгжих газар хөндөх ажлын хяналтын арга хэмжээний үр дүн; зэрлэг амьтдад үзүүлэх нөлөөллөөс зайлсхийх үүднээс ХМБ-ийн сангийн усны чанарыг хууль, журамд заасан хязгаар дотор барих; тээврийн хэрэгсэлд зэрлэг амьтан дайруулах эрсдлийг багасгахад чиглэсэн замын хөдөлгөөний менежментийн хяналтын арга хэмжээний хяналт шинжилгээ зэрэгт төвлөрнө. Үүнээс гадна холбогдох төлөвлөгөөнүүдэд тодорхойлсончлон хүчиллэг чулууллагийн урсац болон гадаргын усны менежментийн хяналт шинжилгээ нь гадаргын усыг зайлуулахаас үүсэх нөлөөллийг тодорхойлж, шаардлагатай тохиолдолд арга хэмжээ авах боломжыг бүрдүүлнэ.

Чухал Биологийн олон янз байдлын төлөв байдалд хяналт шинжилгээ хийснээр хяналтын арга хэмжээнүүдийн үр дүнг илтгэх баримт нотолгоо илүү тодорхой болох ба төсөл хэрэгжисний үр дүнд тохиолдож болзошгүй урьдчилан тооцоолоогүй аливаа нөлөөллийг тодорхойлох боломж олгоно. Уг хяналт шинжилгээ нь төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө илүү нарийн тодорхой болох ба ерөнхийдөө дараах зүйлсийг хамруулна. Үүнд:

- Хууль бусаар мод бэлтгэх явдал нэмэгдсэнээс үүсэх боломжит нөлөөлөл, усны горим өөрчлөгдсөнөөс эсхүл уурхайн тоосжилтоос үүсэх нөлөөллүүдийг тодорхойлох зорилгоор Гацууртын уурхайн орчимд ургамлан нөмрөг, ойн эрүүл мэндийн үнэлгээ хийх;

- Гадаргын усны голдрилд хэсэгчилсэн тохируулга хийх, уурхайн цэвэрлэсэн усыг байгальд нийлүүлснээс үүсч болзошгүй аливаа нөлөөллийг тодорхойлох үүднээс Гацууртын уурхайгаас доошох урсгал дагуух хэсгийн усан орчны экологийн төлөв байдалд үнэлгээ хийх;

- Уурхайн тоосжилт, усны горимын өөрчлөлт, бэлчээрийн даац нэмэгдэснээс үүсч болзошгүй нөлөөллүүдийг тодорхойлох зорилгоор Гацууртын уурхайн эргэн тойрны газар нутгуудад бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх.

Гацууртын уурхайн шинж чанарын улмаас уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаануудын дийлэнхийг ашиглалтын үе шат дуусахын алдад гүйцэтгэж дуусах бөгөөд уурхайн хаалт, нөхөн сэргээлттэй холбоотой хяналт шинжилгээ нь уурхайн хаалт ба нөхөн сэргээлтийн нарийвчилсан төлөвлөгөөнд бүрэн тодорхойлогдоно. Уг нарийвчилсан төлөвлөгөөг ашиглалт дуусч Гацууртыг уурхайг хаахаас гурван жилийн өмнө боловсруулсан байна.

Төслийн стандартуудад үл нийцэж байгаа нь хяналт шинжилгээгээр тогтоогдсон тохиолдолд түүний мөрөөр үзлэг шалгалт хийж, зохих засаж залруулах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

7.2 Хяналт шинжилгээний гол үйл ажиллагаа

Хяналт шинжилгээний гол үйл ажиллагаанууд нь биологийн олон янз байдлын менежмент, сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ болон төслийн үйл ажиллагаа сөрөг нөлөө үзүүлж байгаа эсэхийх үнэлэх боломж олгох биологийн олон янз байдлын тодорхойлогдсон индикаторуудад төвлөрнө. Хяналт шинжилгээний үр дүнд төслийн стандартуудад үл нийцэх зөрчил илэрсэн тохиолдолд үүнийг осол зөрчил хэмээн бүртгэж, үзлэг шалгалт хийж, засаж залруулах арга хэмжээг тодорхойлно.

Хяналт шинжилгээний гол арга хэмжээнүүдийг дор үзүүлэв.

Хүснэгт 3: Хяналт шинжилгээний гол арга хэмжээнүүд

Лавлах дугаар	Хамрах сэдэв /асуудал	Арга зүй	Давтамж	Байршил
БОЯБМ01	Ургамлан нөмрөг	Гацууртын уурхайн эргэн тойрны ой болон гол эрэг орчмын ургамлан нөмрөгийн төлөв байдал: хяналт шинжилгээний цэг – ургамлан нөмрөгийн төлөв байдал; титэм; бүрхэц; зүйлийн олон янз байдал.	Жил бүр	Уурхайн үйл ажиллагаа явагдаж буй талбайгаас 1 км доторх хяналтын цэг ба талбай .
БОЯБМ02	Усан амьдрах орчин	Сонгосон дээж талбай дахь зүйлийн олон янз байдал, элбэгшил, тохиолдоц	Жил бүр	Гацууртын уурхайгаас доошох урсгал дагуух хяналтын байошил, цэгүүд
БОЯБМ03	Бэлчээр	Хүлээн зөвшөөрөгдсөн индексийг ашиглан бэлчээрийн төлөв байдлыг шинжлэх.	Жил бүр	Гацууртын үйл ажиллагаа явагдаж буй талбайгаас 1 км доторхи хяналтын талбайнууд.
БОЯБМ04	Газар хөндөх/хөрс хуулах	Газар хөндөх үйл ажиллагаа зөвшөөрөгдсөн талбайд явагдаж байгаа эсэхийг хянаж шинжлэх	Жил бүр	Гацууртын үйл ажиллагаа явагдаж буй талбай болон туслах зам
БОЯБМ05	Тээврийн хэрэгсэлд зэрлэг амьтан дайруулах	Уурхайн тээврийн хэрэгсэлд мөргүүлж эндсэн зэрлэг амьтны осол, зөрчлийг бүртгэж байх	Тогтмол	Бүгд
БОЯБМ06	Хаягдлын байгууламж, ил уурхай болон цөөрмүүдэд зэрлэг амьтан орж үхэж хорогдох	Уурхайн ил задгай цөөрөм, хаягдлын байгууламж, ил уурхай болон уурхайн ус цэвэрлэх системд зэрлэг амьтан үхэж хорогдсон бүх тохиолдлыг бүртгэж байх	Тогтмол	Бүгд

8 СУРГАЛТ

Гацууртын бүх ажиллагсад болон гэрээт гүйцэтгэгчдийг үндсэн болон гэрээт ажиллагсадад зориулсан зааварчилгааны хөтөлбөрүүдээр дамжуулан байгаль орчны мэдлэг олгох, уурхайн талбайн дүрмүүдийг танилцуулах үндсэн сургалтанд хамруулна. Биологийн олон янз байдлын

хяналт шинжилгээний ажилд оролцох Байгаль орчны хэлтсийн ажилчдад болон тээврийн хэрэгслийн жолооч нарт мал амьтан дайрч мөргөхөөс зайлсхийх зэрэг тээврийн хэрэгслийг аюулгүй, зөв зохистой ашиглахад чиглэсэн нэмэлт сургалтаар хангана.

9 АУДИТ БА ТАЙЛАГНАЛ

9.1 Дотоод аудит

Үйл ажиллагаа хариуцсан ахлах ажилчид Гацууртын уурхайд, тээвэрлэлтийн үйл ажиллагаа дайран өнгөрч буй газрууд, Бороогийн уурхайн боловсруулах байгууламжууд болон хаягдлын байгууламжид тогтмол үзлэг шалгалт *(хамгийн багадаа долоо хоног бүр)* хийх бөгөөд уг үзлэгт зэрлэг амьтдад үзүүлэх мэдэгдэхүйц илт нөлөөллийг таньж тодорхойлох, тоосжилтын хяналт, битүүмжлэл алдагдах, ус цэвэрлэх систем доголдох, төлөвлөгдөөгүй байгальд хаягдал нийлүүлэх, зөвшөөрөлгүй газар хөндөх зэрэг өргөн хүрээний эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны асуудлуудыг хамруулна.

Эдгээр үзлэг шалгалтын үеэр тодорхойлогдсон аливаа осол зөрчлийг осол зөрчлийн менежментийн системд тайлагнана.

Нийцлийг БГК-ийн ЭМААБОМС-д заасны дагуу жил тутмын дотоод аудитын хөтөлбөрөөр хянаж байна. Үүнийг менежментийн системний *(БОННҮ болон менежментийн төлөвлөгөөнүүдийг мөн хамруулан)* шаардлагуудыг өргөн хүрээнд дагаж мөрдөж байгаа эсэхэд үнэлгээ хийх зорилготой хэрэгжүүлнэ.

9.2 Хөндлөнгийн аудит

Сентеррагийн аудитын хөтөлбөрийн хүрээнд болон төслийн зээлдүүлэгчдийн зүгээс энэхүү төлөвлөгөөний биелэлтэд тогтмол үнэлгээ хийнэ.

9.3 Бүртгэл хөтлөх

Аудит, үзлэг шалгалт, осол зөрчлийн бүртгэл хөтлөлтийг Гацууртын журмуудад заасны дагуу хийнэ.